



НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР



АРДЧИЛЛЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ҮҮРЭГ

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН
ОРОЛЦООГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ
ТАЛААРХ САЙН ТУРШЛАГА,
ГАРЫН АВЛАГА

ӨМНӨХ ҮГ: НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Жендэрийн тэгш байдал бий болгох, эмэгтэйчүүдийн эрхийг өргөжүүлэх асуудал нь хүний эрхтэй салшгүй холбоотой төдийгүй тэнцвэртэй, тогтвортой хөгжлийн суурь хүчин зүйл юм. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай бөгөөд энэхүү оролцоог хөхиүлэн дэмжих, тэтгэх гол байгууллага нь улс төрийн намууд юм. Дэлхий даяар парламентад эзлэх эмэгтэйчүүдийн хувь 20-иос доош байгаа нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх талаар улс төрийн намууд цаашид их зүйл хийх, тэдэнд энэ зорилтыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Олон улсын дунджаар, улс төрийн намын гишүүдийн 40-50 хувь эмэгтэйчүүд байгаа боловч тэдний ердөө 10 хүрэхгүй хувь нь намын удирдах албан тушаал хашдаг ажээ. Намуудын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг адил тэгш оролцуулах нь намуудын дотоодод төдийгүй нийгэмд бүхэлдээ жендэрийн тэгш байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

НҮБХХ болон АҮХ жил хагасын дотор эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр улс төрийн намаас явуулж байгаа үйл ажиллагааны талаар 20 кейс судалгааг хийсэн юм. Эдгээр судалгаа болон бусад жишээнд үндэслэн НҮБХХ, АҮХ хамтран улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийг хөхиүлэн дэмжих чиглэлээр улс төрийн намуудаас авч явуулах арга замуудын талаар зөвлөмж гаргаж байна. “Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрийн намуудын үүрэг: Улс төрийн оролцоог нэмэгдүүлэх сайн туршлага ба гарын авлага” сэдэвтэй товхимол нь тус судалгааны үр дүн бөгөөд улс төрийн намын шинэтгэлийн талаар тодорхой чиглэлийг гаргаж байна.

Тус товхимол нь сонгуулийн мөчлөгийн бүх шат буюу сонгуулийн үеэр, түүний өмнөх болон дараагийн шатанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар улс төрийн намуудаас авч явуулах арга хэмжээг тодорхойлж, эрэмбэлсэн анхны хэвлэл юм.

Тус товхимолыг улс төрийн намын гишүүд, ялангуяа түүний удирдлага, иргэний нийгмийн байгууллагууд, жендэрийн тэгш байдлыг дэмжигчдэд зориулан гаргав. Түүнчлэн улс төрийн намын олон улсын сан, холбоодод жендэрийн тэгш байдлыг үйл ажиллагаа, дүрэм журамдаа хэм хэмжээ болгон ашиглахад зориулав.

Эцэст нь, тус товхимол эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр улс төрийн намуудад дэмжлэг үзүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг олон улсын болон хөгжлийн байгууллагуудад үнэтэй зөвлөмжийг тусгасан болно.

Эмэгтэйчүүд улс төрөөс эхлээд төрийн алба, хувийн салбар, иргэний нийгэм хүртэл засаглалын бүхий л институцид бодит дуу хоолойгоо хүргэх боломжтой болсон цагт тэд төрийн бодлого боловсруулахад эрэгтэйчүүдтэй тэгш эрхтэй оролцож, өөрсдийн болон гэр бүл, орон нутаг, улс орны ирээдүйг тодорхойлох шийдвэр гаргахад нөлөөлж чадна.



ХЕЛЕН КЛАРК
НҮБ-ын Хөгжлийн
хөтөлбөрийн Захирагч

ӨМНӨХ ҮГ: АРДЧИЛЛЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Улс төрийн намууд бол эмэгтэйчүүд сонгуульт албан тушаал, улс төрийн удирдлагад хүрэх хамгийн эхний бөгөөд шууд механизм учраас улс төрийн намуудын бүтэц, бодлого, практик, үнэт зүйлс тухайн орны улс төрийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцоонд чухал нөлөөтэй байдаг.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих нь намуудад сонгуулийн өрсөлдөөнд давуу байр суурь эзлэх, шинэ сонгогчдыг татах, сонгогчидтой харилцах харилцаагаа бэхжүүлэх зэрэг олон давуу тал олгодог. Үүний зэрэгцээ сонгогчдын идэвх буурч байгаа өнөө үед шинэ дүр төрх, санаа гаргаж тавих нэн шаардлагатай болж байна. Амжилт заримдаа огцом, эсвэл өчүүхэн бага, заримдаа аажимдаа гардаг ч улс төрийн намууд ерөнхийдээ аль ч тохиолдолд хожсон дүнтэй байна.

Сонгуулийн болон засаглалын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд оролцоод зогсохгүй, түүнд нөлөөлдөг байх нь улс төрийн намуудад ашигтай юм. Эмэгтэйчүүдэд бодитоор нөлөөлөх боломж, шийдвэр гаргах эрх мэдэл өгөх зэрэг чанарын өөрчлөлт хийлгүй зөвхөн тоог нэмэгдүүлснээр түргэн амжилтад хүрэхгүй. Иймэрхүү жишээнд намын эмэгтэйчүүдийн жигүүрийг албан ёсны статусгүй байгуулах, эмэгтэйчүүдийг намын нэр дэвшигчийн жагсаалтад ор нэр төдий байрлуулах, сонгогдсон хойно нь гадуурхах, тэднийг сонгогдох боломж муутай дүүргүүдэд хуваарилах, нэр дэвшигчийн жагсаалт дахь боломжийн байршлаас хугацаа тулсан үед хасах зэргийг дурдаж болно.

Дэлхий нийтээрээ хүйсийн хооронд тэнцвэртэй, тэгш байдалд үндэслэсэн ардчилсан засаглалын хандлага руу шилжиж байна. Эмэгтэйчүүд зэрэг төлөөлөл нь хангагдаагүй бүлгүүдэд хүрч ажиллах нь улс төрийн намууд, тэдний үйл ажиллагааны удирдлага болсон хууль тогтоох байгууллагуудын ардчилсан үйл ажиллагааны минимум хэм хэмжээ болоод байна.

Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрийн намуудын үүрэг: Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хөхиүлэн дэмжих сайн туршлага, гарын авлага хэмээх тус товхимолыг сонгуулийн мөчлөгийн турш эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх стратеги, намуудын доторхи үүргийг тодорхойлоход улс төрийн намууд, тэдэнтэй ажиллаж буй байгууллага, хүмүүст тустай байдлаар боловсруулав. Эмэгтэйчүүдийн оролцоог зөвхөн нэр дэвшигчийн төдийгүй намын гишүүн, удирдагч, албан тушаалтны хувьд хөхиүлэн дэмжих хэрэгтэй.



Кен Уоллак
Олон улсын харилцааны газар,
Ардчиллын Үндэсний Хүрээлэнгийн
Ерөнхийлөгч

ТОВЧ АГУУЛГА




UNDP PAKISTAN

Улс төрийн амьдралд оролцох эмэгтэйчүүдийн эрхийг олон улсын хэд хэдэн конвенциор хамгаалсан байдаг. Гэвч тус абстракт эрхийг бодит зүйл болгоход амьдрал дээр ихээхэн хүч хөдөлмөр шаардагдаж байна. Улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигчдийг тодруулж, улс орны бодлогыг тодорхойлдог учраас улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны хувьд хамгийн чухал байгууллага юм. Гэтэл улс төрийн намуудын анхан шатны байгууллагууд болон туслах албан тушаалд эмэгтэйчүүд маш олноор ажилладаг хэрнээ эрх мэдэл бүхий удирдах албан тушаалыг маш цөөн тооны эмэгтэйчүүд хашиж байна. Улс төр дэх эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдтэй харьцангуй цөөн байгаа нь тэд нөлөөллийн том сүлжээ, бүлэгт багтаж чадахгүй, хөрөнгө мөнгө туйлын хязгаарлагдмал, үлгэр дууриал болох ба зөвлөгөө өгөх хүн цөөн, тэр ч байтугай гэр бүл, ойр дотныхоо хүрээнд дэмжлэг авч чаддаггүйтэй холбоотой нь ойлгомжтой.

Улс төрийн намуудад эмэгтэйчүүд хэрхэн оролцож байгаа, эдгээр нам нь эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн дэмжиж, жендэрийн тэгш байдлыг үйл ажиллагаандаа хэрхэн тусгаж байгаагаас эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг нэмэгдүүлэх асуудал ихээхэн хамаарна. Нийгмийн өргөн хүрээнд жендэрийн тэгш байдал бий болгоход улс төрийн намууд мөн шийдвэрлэх үүрэгтэй. Улс төрийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх стратегийг үр нөлөөтэй болгоё гэвэл намууд сонгуулийн мөчлөг буюу сонгуулийн өмнөх, сонгуулийн үеийн болон дараах шатууд болон намын зохион байгуулалт, санхүүжилттэй холбон авч үзэх хэрэгтэй.

Улс төрийн намууд дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хамгийн үр дүнтэй стратеги нь улс төрийн институцийн шинэтгэлийг намын гишүүн болон гишүүн бус идэвхтэй дэмжигч эмэгтэйчүүд, эмэгтэй нэр дэвшигчид, сонгуульт албан тушаалтнуудад тусгайлан үзүүлэх дэмжлэгтэй хослуулан хийх явдал юм. Энэ стратегийг хэрэгжүүлэхэд улс төрийн намууд, бусад бүх оролцогч талын хамтын ажиллагаа шаардлагатай болно.

Тус гарын авлагад эмэгтэйчүүдийн эрхийг өргөжүүлэхийн тулд улс төрийн намуудаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлов. Эдгээр арга хэмжээг сонгуулийн мөчлөгийн хандлагын дагуу дөрвөн үе шатад хуваан авч үзлээ.



Сонгуулийн үе шат бүрт улс төрийн намуудын хэрэгжүүлэх тусгайлсан арга хэмжээг хураангуйлан харуулав.

ЗУРАГ 1. УЛС ТӨРИЙН НАМУУДАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

I. НАМЫН ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Эрх зүйн хүрээ, бодлогын баримт бичиг жендэрийн мэдрэмжтэй байх.
- Намын удирдах зөвлөл, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг оролцуулах

II. СОНГУУЛИЙН ӨМНӨХ ШАТ

| НЭР ДЭВШИГЧИЙГ ТОДОРХОЙЛОХ | САНХҮҮЖИЛТ БА КАМПАНИТ АЖИЛ |
|--|--|
| Эмэгтэйчүүдийг сонгуульд оролцуулах талаар намын удирдлагын хүрээнд зөвшилцөл бий болгох | Санхүүгийн дэмжлэг эртнээс олж авах, сурталчилгаа хийх, өөрийгөө таниулах үр чадвар олгох |
| Эмэгтэй нэр дэвшигчийн намын сайн дурын квотыг тогтоож, холбогдох дүрэм журамд тусгах | Эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих сан байгуулах, эсвэл хөрөнгө босгох сүлжээнд хамруулах |
| Сонгуулийн хугацаанд нийцүүлэн намын удирдлагаас нэр дэвшүүлэх журмыг тогтоох | Намын дотоод сан байгуулах, эсвэл эмэгтэй нэр дэвшигчдэд татаас олгох |
| Намын жагсаалтад эмэгтэйчүүдийг ялах магадлалтайгаар байрлуулах, эсвэл сонгогдох магадлалтай тойрогт нэр дэвшүүлэх. | Нэр дэвших, сонгуульд өрсөлдөхөд зарцуулах хөрөнгийн дээд хязгаар тогтоох |
| Эмэгтэйчүүдийг татах хөшүүрэг бий болгох, чадавхи бий болгох, сурталчилгаа хийх замаар тэднийг намд элсэх явдлыг дэмжих. | Намын санхүүгийн тодорхой хэсгийг эмэгтэй нэр дэвшигчид, сургалтад зарцуулах (улсын төсвийн санхүүжилтыг оролцуулан) |
| Эмэгтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх ИНБ, бусад байгууллагатай ажлаа уялдуулах | Түншлэл бий болгож, олон улсын байгууллага, ИНБ-тай хамтран ажиллах |
| Стратегийн түншлэл бий болгох, эрэгтэйчүүдийн дэмжлэгийг авах | |

Намын дотоодод эмэгтэйчүүдийн байгууллага чухал байр суурь эзэлсэн байх.

Намын их хуралд оролцох эмэгтэйчүүдийн тоог тогтоосон байх.

Хөгжлийн бодлогод жендэрийн тэгш байдлын үзэл санааг тусгах



III. СОНГУУЛИЙН ҮЕ

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕ

Сурталчилгаа хийх чадавхи бий болгох, анх нэр дэвшиж байгаа эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх

Сонгуулийн сурталчилгааны үед эмэгтэйчүүдийг нийтэд таниулах, ХМХ-ээр хэрэгслүүдээр сурталчлах

Жендэрийн тэгш байдлын талаар намын мөрийн хөтөлбөр гаргаж сонгогчдод сурталчилах

Эмэгтэй сонгогчдыг бүртгүүлэх, санал өгөхөд уриалах, жендэрийн мэдрэмжтэй мэдээллийг эрэгтэй, эмэгтэй сонгогчдод өгөх

Сурталчилгааны үеэр эмэгтэй нэр дэвшигчдийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл гарч болох газар намын дэмжигчдийг байлгах

Эмэгтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлж буй ИНБ, бусад байгууллагатай хамтран ажиллах

СОНГУУЛИЙН ӨДӨР

Сонгуулийн хороо, хэсгүүдэд намыг төлөөлж ажиллах эмэгтэйчүүдийг сургах

Эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах, сонгуулийн мониторинг хийхэд жендэрийн асуудлыг харгалзах

Сонгуулийн мониторинг хийхэд эмэгтэйчүүдийг сургах, тэднийг оролцуулах



IV. СОНГУУЛИЙН ДАРААХ ШАТ

СОНГОГДСОН ЭМЭГТЭЙЧҮҮД

Жендэрийн тэгш байдлын үнэлгээ хийх, намын дотоод үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Сонгогдсон эмэгтэйчүүдийн хууль боловсруулах үр чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Улс төрийн институци, ялангуяа парламентад жендэрийн мэдрэмжтэй шинэтгэл хийх

Намын бодлого боловсруулахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, намын бодлогод жендерийн асуудлыг тусгах

Намууд хоорондын бүлэг үүсгэх санаачилгыг дэмжиж үйл ажиллагаанд нь туслалцаа үзүүлэх

Жендэрийн тэгш байдлын талаар намын гишүүдийн мэдлэгийг нэмэгдүүлж, эрэгтэйчүүдтэй хамтран ажиллах

Улс төрийн намуудын дотоод зохион байгуулалт нь олон ашиг сонирхол, эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлага хэрхэн төлөөллөө олоход нөлөөлдөг. Улс төрийн намын албан ёсны баримт бичиг, тунхаглал нь тухайн намын алсын хараа, тавьж буй зорилтууд, эдгээр зорилтод хэрхэн хүрэх арга замыг тодорхойлдог учраас жендэрийн тэгш байдлыг хангахад чухал ач холбогдолтой баримт бичиг юм. Намын дотоод стратегид дараах зүйлс багтана:

Намын дүрэмд жендэрийн тэгш байдлыг тусгах. Намын баримтлах үндсэн баримт бичигт жендэрийн тэгш байдлыг албан ёсоор тунхаглах.

Намын удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн оролцоог хангахын тулд квот тогтоох зэрэг дотоод арга хэмжээ авах

Намын их хуралд оролцох эмэгтэйчүүдийн тоог тогтоох. Үүнд хурлын төлөөлөгч эмэгтэйчүүдэд зориулсан чуулган зохион байгуулах зэрэг байж болно.

Намын албан ёсны бүтцийн дотор эмэгтэйчүүдийн байгууллага, эсвэл жигүүр байгуулах, түүний үүрэг, хариуцлага, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох.

Намын бүх бодлогод жендэрийн асуудлыг тусгах

СОНГУУЛИЙН ӨМНӨХ ШАТАНД нэр дэвшигчийг тодорхойлж, томилох асуудал нь улс төрд эмэгтэйчүүдийг оролцуулах хамгийн чухал алхам юм. Тухайн намыг дэмжигч байхаас эхлээд бодитоор нэр дэвших хүртэл жендэрийн ялгаа улам нэмэгддэг. Иймд намууд эмэгтэйчүүдийн төлөөллийг баталгаажуулах дүрэм баталж, мөрдөх нь чухал. Энэхүү үүрэг амлалт бичигдээгүй, албан бус тохиолдолд эмэгтэйчүүд эрх мэдлийн хүрээнд нэвтрэн орох стратеги боловсруулах, амлалтаа биелүүлээгүй нөхцөлд намуудтай хариуцлага тооцох хүндрэлтэй байдаг. Намын дотоод зохион байгуулалт сул, нэр дэвшүүлэх тодорхой журамгүй нөхцөлд шийдвэрийг цаан тооны элит эрэгтэйчүүд хандлагатай байдаг.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд сонгуулийн квотыг бодлогын нийтлэг арга хэмжээ болгон сүүлийн жилүүдэд ашиглаж байна. Квот нь төлөөлөгч, нэр дэвшигч, сонгуульт албан тушаалд эмэгтэйчүүд зэрэг сонгуулийн тодорхой бүлгийн гишүүдийн төлөөллийг баталгаажуулан доод хувийг заах арга хэрэгсэл юм. 50 гаруй оронд улс төрийн албан тушаалд нэр дэвшигчдийн тодорхой хувь эмэгтэйчүүд байх хууль батлан хэрэгжүүлж байна. 30 гаруй орны олон зуун улс төрийн нам эмэгтэй нэр дэвшигчийн сайн дурын квот тогтоожээ. Гэвч нэр дэвшигчийн квот нь зөвхөн эмэгтэйчүүдийг намын жагсаалтад ашигтайгаар байрлуулсан, эс биелүүлсэн нөхцөлд хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд л үр дүнтэй хэрэгсэл болно.

Нэр дэвшигчийг тодруулах ажиллагаанд жендэрийн тэгш бус байдлыг арилгахын тулд улс төрийн намууд дараах арга хэмжээ авч болно. Үүнд:

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ НИЙГМИЙН ӨРГӨН ХҮРЭЭНД БИЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРЭГТЭЙЧҮҮДИЙГ ОРОЛЦУУЛАХ НЬ ЧУХАЛ.

Нэр дэвшигчийн квотыг хэрэгжүүлэхэд намын дэмжлэгийг авах, намын дүрэмд тусгах

Намын удирдах зөвлөл зэрэг нэр дэвшүүлэх эрх бүхий байгууллагын ажлын удирдамжийг бий болгох

Эмэгтэй нэр дэвшигчийг ялах магадлалтай тойрогт хуваарилах

Квотын хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагатай хамтран хяналт тавих

Эрэгтэйчүүд намын дотоод дэмжлэг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг тул тэдэнтэй стратеги түншлэл тогтоох

Эмэгтэй нэр дэвшигчийн тоог нэмэгдүүлж, тэднийг сургах

Бусад улс орон, бүс нутагтай олон талт хамтын ажиллагаа тогтоож, туршлага солилцох

Эмэгтэйчүүд улс төрд ороход саад болж байгаа гол хүчин зүйлсийн нэг нь хөрөнгө мөнгөний хомсдол гэж ярьдаг. Эмэгтэйчүүдэд сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардагдах хөрөнгө босгоход ихээхэн хүндрэл гарахын хажуугаар улс төрийн намуудаас санхүүгийн туслалцаа маш бага, эсвэл огт авдаггүй байна. Ялангуяа тэдэнд сонгуулийн сурталчилгааг эхлүүлэхэд шаардагдах санхүүжилтийг олоход хүнд байдаг. Сонгуулийн кампанит ажил явуулахад шаардагдах хөрөнгө босгоход намууд болон ИНБ эмэгтэйчүүдэд дараах дэмжлэгийг үзүүлж болно. Үүнд: төсвийн санхүүжилт байхгүй, нэр дэвшигчид сонгуульд өрсөлдөхийн тулд хувиасаа хөрөнгө гаргаж байгаа нөхцөлд санхүүжилт бий болгох сүлжээ ажиллуулах; эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих санг намын дотор байгуулах; эмэгтэй нэр дэвшигчдэд татаас олгох; нэр дэвшүүлэх, сонгуулийн кампанит ажлын зардалд хязгаар тогтоох; эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжиж байгаа намуудыг урамшуулах зорилготоор намуудад төсвөөс санхүүжилт өгөх;

эмэгтэй нэр дэвшигчдийг сургахад зориулсан тусгай санхүүжилт бий болгох, эмэгтэй нэр дэвшигчид болон эмэгтэйчүүдийн асуудлыг дэмжихэд намын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих эдгээр болно.

СОНГУУЛИЙН ҮЕЭР нэр дэвшигчид сонгогчидтой харилцах, сурталчилгаа хийх үр нөлөөтэй арга техник эзэмшсэн байх хэрэгтэй. Эмэгтэйчүүдийн улс төрд оролцох эрх, жендэрийн тэгш байдлын нийгмийн ач холбогдлын талаар сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэхэд улс төрийн намууд тусалж болно. Энэ шатанд намуудаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Эмэгтэй нэр дэвшигчдэд хөрөнгө босгох, мессэж боловсруулах, хэвлэл мэдээлэл, сонгогчидтой харилцах ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах.

Сонгуулийн кампанит ажлыг удирдахад эмэгтэйчүүдийг оролцуулах, тэднийг сургах (кампанит ажлын менежмент, сонгогчдын дэмжлэгийг татах, сонгогчидтой холбоо тогтоох, харилцах зэрэг)

Сонгуулийн кампанит ажлыг удирдахад эмэгтэйчүүдийг оролцуулах, тэднийг сургах (кампанит ажлын менежмент, сонгогчдын дэмжлэгийг татах, сонгогчидтой холбоо тогтоох, харилцах зэрэг)

Эмэгтэйчүүдийг олон нийтэд таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр илүү гаргах кампанит ажил өрнүүлэх

Эмэгтэйчүүдийн асуудлаарх тэргүүлэх чиглэлийг харуулсан намын байр суурийг гаргаж нийтэд дэлгэрүүлэх, ингэснээр намд илүү эмэгтэй сонгогчдын саналыг авах.

Сонгуулийн мониторинг хийх, ялангуяа эмэгтэй нэр дэвшигч өрсөлдөж байгаа сонгуулийн хэсэгт намыг төлөөлсөн эмэгтэйчүүдийг ажиллуулах

Эмэгтэйчүүдийн саналын ач холбогдол, нийгмийн тэгш эрхтэй гишүүний хувьд эмэгтэйчүүдийн эрхийг онцолсон мэдээлэл боловсруулж сонгогчдод өгөх

СОНГУУЛЬ ДУУССАНЫ ДАРАА ч эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрийн намуудын үүрэг чухал хэвээр байх болно. Сонгуулийн дараа жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, засаглалын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн эрхийг өргөжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч болно. Үүнд:

Эмэгтэйчүүдийг шууд болон шууд бусаар ялгаварлын гадуурхаж буй практик, дүрэм журмыг тодорхойлох, эцэст нь таслан зогсоох зорилгоор намын дотоодод жендэрийн үнэлгээ хийх

Улс төрийн байгууллауудад жендэрийн мэдрэмжтэй өөрчлөлт шинэчлэл хийх, тухайлбал, парламентын хуралдааны цагийн хуваарийг өөрчлөх, парламентын гишүүдийн гэр бүлдээ зарцуулах цагийг нэмэгдүүлэх зорилгоор хуанлид өөрчлөлт хийх зэрэг.

Намын бодлогод жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх, нөхөн үржихүйн эрх, хүүхдээ асрах чөлөө зэрэг жендэрийн асуудлыг тусгасан бодлогын шинэчлэлийг дэмжих, эрх зүй, эрүүл мэнд, харьяалал, хөдөлмөр, газар эзэмших, нийгмийн хамгаалал, өв хөрөнгө залгамжлах зэрэгт жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих зэргээр жендэрийн болон эмэгтэйчүүдийн асуудлыг тусгах.

Эмэгтэйчүүдийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлэх, жендэрийн асуудлыг бодлогод тусгах, засгийн газрын хяналтыг сайжруулахын тулд намууд хоорондын эмэгтэй гишүүдийн сүлжээ, парламентын эмэгтэй гишүүдийн бүлгийг дэмжих,

Улс төрийн институцид сонгогдсон эмэгтэйчүүдийг парламентын бүлэг, байнгын хорооны дарга зэрэг удирдах албан тушаалд ажиллуулах

Иргэний нийгмийн байгууллагуудтай стратегийн түншлэл тогтоох.

Санал болгож буй дээрх арга хэмжээ нь сайн туршлагад үндэслэсэн бөгөөд заавал хэрэгжүүлэх жор гэхийн оронд чиглэл болгон өгч байна гэдгийг ойлгох хэрэгтэй. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хөхиүлэн дэмжих, жендэрийн тэгш байдлыг өргөн хүрээнд сайжруулахад эрэгтэйчүүдийн оролоо чухал. Урт хугацааны өөрчлөлт хийхэд эрэгтэйчүүд гол түнш юм. Улс төрд оролцох эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлнэ гэдэг нь эрэгтэйчүүдийн тоог цөөлнө гэсэн үг биш, харин хүн бүрт илүү тэгш нийгмийг цогцлон бүрдүүлнэ гэсэн үг юм.

УЛС ТӨРД ОРОЛЦОХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛНЭ ГЭДЭГ НЬ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ТООГ ЦӨӨЛНӨ ГЭСЭН ҮГ БИШ, ХАРИН ХҮН БҮРТ ТЭГШ НИЙГМИЙГ ЦОГЦЛОН БҮРДҮҮЛНЭ ГЭСЭН ҮГ ЮМ.



United Nations Development Programme
Bureau for Development Policy
One United World Plaza
New York, NY, 10017 USA
Tel. +1 212 906 6305

For more information:
www.undp.org/governance



National Democratic Institute
for International Affairs
455 Massachusetts Ave, NW, 8th Floor
Washington, DC 20001-2621
Tel. +1 202 728 5500

For more information:
<http://www.ndi.org>

ISBN 978-0-9848059-0-7
9 0000 >

